

Сэдэв: Далайн ТЭЭВЭРЛЭЛТ



Далайн, тэнгисээр хүрээлэгдсэн буюу алслагдсан улс орнуудын хооронд олон улсын худалдаа хийхэд хамгийн тохиромжтой гэж тооцогддог тээврийн хэрэгсэл нь далайн тээвэр юм.

Их хэмжээний бараа бүтээгдэхүүн, ачаа тээшийг тээвэрлэхэд далайн тээвэрлэлт хамгийн хямд зардалтай учраас улс орнууд далайн тээвэрлэлтийг түгээмэл ашиглаж байна.

Хэдийгээр манай улс далайд гарцгүй боловч далайн тээврээр дамжуулан импортын бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн дийлэнх хэсгийг худалдаж авдаг.



- Хол зайд их хэмжээний бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд нэгж жинд ногдох өртөг хямд
- Их хэмжээний бараа болон хүнд бараа тээвэрлэхэд тохиромжтой
- Хэмжээ болон жингийн хязгаарлалт байхгүй
- Ямар нэгэн тусгайлсан зам болон шугам тавих шаардлагагүй
- Олон улсын чанартай



- Тээврийн хурд удаан
- Тээвэрлэх тоо бага
- Цаг агаараас шалтгаалдаг учир тээвэрлэх төлөвлөгөөнд шууд нөлөөлнө
- Усан боомтод байгуулах, агуулах, янз бүрийн төхөөрөмжинд гарах зардал өндөр
- Тээвэрлэлтийн явцад эд бараа, бүтээгдэхүүн гэмтэж, эвдрэх магадлал их






- Олон улсын далайн тээвэрлэлт нь зохион байгуулалтын хоёр хэлбэртэй:
 - ✓ Шугамын тээвэрлэлт /Тогтмол/
 - ✓ Шугамын бус тээвэрлэлт /Тогтмол бус/



- *Шугамын тээвэрлэлт* гэдэг нь газар зүйн тогтсон маршрут, урьдчилан зарласан хуваарийн дагуу, байнга тогтмол хийдэг тээвэрлэлтийг хэлдэг. Далайн шугамын тээвэрлэлтийн үед урьдчилан тогтоосон тарифын дагуу тээврийн хөлсийг нь төлдөг бөгөөд тээвэрлэлтийн тариф нь ихэнхдээ урт удаан хугацааны туршид тогтвортой мөрдөгддөг байна.
- *Шугамын бус тээвэрлэлтийн* шугамын тээвэрлэлтээс ялгагдах онцлог нь хөлөг онгоцны тогтмол бус рейсээр ачааг тээвэрлэдэг явдал юм. Шугамын бус тээвэрлэлт хийдэг далайн тээврийн байгууллагууд шугамын тээвэрлэлтээс арай доогуур тарифыг мөрддөг байна.

- Чингэлэг тээврийн
- Жижиг буюу авдар, савтай ачааны
- Нефть ба бусад шингэн бодисын
- Түлшний модны
- Хүнд жинтэй, овор хэмжээ ихтэй ачааны
- Түргэн гэмтэж, муудах ачаа барааны
гэх мэт дотроо олон төрөлтэй



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

